

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 4 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгалын нөөцийн санг бүрдүүлэх,
зарцуулах, түүнд хяналт тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, Даатгалын тухай хуулийн 14.2.3, 51, 80 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Урт хугацааны даатгалын нөөцийн санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмыг 2008 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН НӨӨЦИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 14.2.3, 51, 80-д даатгалын нөөц сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь урт хугацааны даатгалын нөөцийн сан (цаашид "даатгалын нөөцийн сан" гэх)-г бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанид (цаашид "даатгагч" гэх) хамаарна.

Хоёр. Даатгалын нөөцийн сан

2.1.Даатгалын нөөцийн сан нь урт хугацааны даатгалын гэрээний дагуу даатгагчаас даатгуулагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлага буюу ирээдүйд төлөх даатгалын нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байна.

2.2.Даатгагч нь даатгалын нөөцийн санг даатгалын актуар тооцоололд үндэслэн даатгалын гэрээ тус бүрээр тооцох бөгөөд эдгээр нөөцийн сангуудын нийлбэрээр даатгалын нөөцийн сан нь тодорхойлогдоно. Даатгалын нөөцийн сан хоёр төрөлтэй байна:

2.2.1.Хураамжийн нөөц;

2.2.2.Хохирлын нөөц.

2.3.Хураамжийн нөөц нь орлогод тооцоогүй хураамжийн нөөц, нөхөн төлбөрийн хэлбэлзлийн нөөц, учирч болзошгүй эрсдэлийн нөөцөөс бүрдэнэ:

2.3.1.Орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь даатгуулагчид ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн нөөцийн хэсэг бөгөөд даатгагчийн үйл ажиллагааны зардал нь үүнд орсон байна. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг хувь тэнцүүлсэн хугацааны буюу "pro rata temporis" аргаар тооцно.

2.3.2.Нөхөн төлбөрийн хэлбэлзлийн нөөцийг тодорхойлоход цэвэр хураамжийн тооцоогоор тогтоогдсон нөхөн төлбөрийн тооцооны утгыг тайлангийн бодит утгатай харьцуулсан зөрүүгээр тодорхойлно. Тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь дундаж утгаасаа давсан тохиолдолд энэ давсан хэсгийг нөөцөөс гаргана, хэрэв бодит хэмжээ нь нормативт хэмжээнээс хэтэрсэн бол нөөцийн санг нэмэгдүүлнэ.

2.3.3.Учирч болзошгүй эрсдэлийн нөөцийг давтамж багатай бөгөөд хамралт өндөртэй томоохон сүйрэл авчирч болох эрсдэлийн нөхөн төлбөрт зориулан зарцуулах бөгөөд үүнийг даатгалын актуарчийн тооцоогоор тогтооно.

2.4.Хохирлын нөөцийг нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын нөөц, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц гэж ангилна:

2.4.1.Нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын нөөцийг тухайн тайлант хугацаанд олгогдоогүй байгаа нэхэмжлэлийн дүнгээр тооцно;

2.4.2 Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийг хохирол нь гарсан боловч энэ талаар даатгагчид мэдэгдэж нэхэмжлээгүй байгаа хохирлын дүнгээр тооцно.

Гурав. Даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг бүрдүүлэх

3.1.Даатгалын нийт хураамжийн орлогоос давхар даатгалын хураамжийг хасч даатгалын цэвэр хураамжийг тодорхойлно.

3.2.Давхар даатгалын хураамжийг даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгаж төлсөн төлбөрийн хэмжээгээр тодорхойлно.

3.3.Орлогод тооцсон хураамжийн орлогыг даатгалын цэвэр хураамжийн орлогоос тайлант хугацаанд ногдох хураамжийг орлогод тооцон авсан дүнгээр тодорхойлно. Энэ нь даатгалын цэвэр хураамжийн орлогоос орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг хассан дүнтэй тэнцүү байна.

3.4.Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжийг гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна.

3.5.Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг тооцохдоо үлдэгдэл хураамжийг гэрээний хүчинтэй үлдсэн хугацаа (өдрөөр)-гаар үржүүлж гэрээний нийт хугацаа (өдөр)-нд хувааж тооцно:

$$\text{Орлогод тооцоогүй хураамжийн нөөц} = \frac{\text{Үлдэгдэл хураамж* х Гэрээний хүчинтэй үлдсэн хугацаа}}{\text{Даатгалын нийт хүчинтэй хугацаа}}$$

* - Үлдэгдэл хураамжийг нийт хураамжаас орлогод тооцсон нийт хураамжийг хасч тооцно.

Дөрөв. Бусад нөөцийн санг бүрдүүлэх

4.1.Орлогод тооцсон хураамжаас нөхөн төлбөрийн хэлбэлзлийн нөөц, учирч болзошгүй эрсдэлийн нөөц, учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийг хасч даатгалын үйл ажиллагааны орлогыг тодорхойлно.

4.2.Нөхөн төлбөрийн хэлбэлзлийн нөөцийг тодорхойлоход цэвэр хураамжийн тооцоогоор тогтоогдсон нөхөн төлбөрийн тооцооны утгыг тайлангийн бодит утгатай харьцуулсан зөрүүгээр тодорхойлно. Тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь дундаж утгаасаа давсан тохиолдолд энэ давсан хэсгийг нөөцөөс гаргана. Хэрэв бодит хэмжээ нь нормативт хэмжээнээс хэтэрсэн бол нөөцийн санг нэмэгдүүлнэ.

4.3.Учирч болзошгүй эрсдэлийн нөөцийг давтамж багатай бөгөөд хамралт өндөртэй томоохон сүйрэл авчирч болох эрсдэлийн нөхөн төлбөрт зориулж бүрдүүлэх бөгөөд үүнийг даатгалын актуарчийн тооцоогоор тооцох ба энэ нь даатгалын орлогод тооцсон хураамжийн 10-аас багагүй хувьтай тэнцүү байна.

4.4.Нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын нөөцийг тухайн тайлант хугацаанд олгогдоогүй байгаа нэхэмжлэлийн дүнгээр тооцож байгуулна.

4.5.Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийг даатгалын тохиолдол болчихсон хэдий ч энэ талаар даатгагчид мэдэгдэж нэхэмжлээгүй байгаа хохирлын дүнгээр тооцох бөгөөд энэ хэмжээг актуарын судалгаан дээр үндэслэж тооцно.

4.6.Даатгагч даатгалын нөхөн төлбөрийн зориулалтаар даатгалын нөөцийн бусад сангуудыг байгуулж болох бөгөөд энэ тухай Хороонд урьдчилж мэдэгдэнэ.

Тав. Даатгалын нөөцийн санг зарцуулах

5.1.Даатгуулагчаас тайлант хугацаанд гаргасан нэхэмжлэлийг нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын нөөцөөс барагдуулна.

5.2.Уг нөөц нь даатгалын хохирлыг нөхөн төлөхөд хүрэлцэхгүй болсон тохиолдолд орлогод тооцсон хураамжийн орлогоос нөхөн төлбөрийн дутуу хэсгийг олгоно. Орлогод тооцсон хураамжийн орлого хүрэлцэхгүй болсон нөхцөлд учирч болзошгүй хохирлын нөөцийн сангаас нөхөн төлбөрийн дутууг олгоно.

5.3.Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцөөс даатгагчид ирсэн нэхэмжлэлийн дүнгээр нэхэмжилсэн боловч олгоогүй хохирлын нөөцийг байгуулна.

5.4.Байгуулсан даатгалын нөөцийн сан гэрээний төлбөр төлөхөд хүрэлцэхгүй болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

5.5.Урт хугацааны даатгалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд даатгалын нөөцийн сангийн хөрөнгийн хэмжээ хүрэлцэхгүй болсон тохиолдолд даатгагч, түүний хараат болон охин компани ногдол ашиг төлөх буюу төлөхөөр зарлахыг хориглоно.

5.6.Даатгалын нөөцийн санг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд сангийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.

Зургаа. Даатгалын нөөцийн санд тавих хяналт

6.1.Даатгагчийн даатгалын нөөцийн сангийн тооцооллыг Хорооноос урт хугацааны даатгалын актуарчийн эрх авсан актуарч баталгаажуулсан байна.

6.2.Даатгагч даатгалын нөөцийн сангийн тооцооллыг жил бүр гаргах үүрэгтэй.

6.3.Даатгалын нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд Хороо улирал бүр хяналт тавина.

6.7.Даатгагч даатгалын нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг Хорооноос баталсан маягтуудын дагуу улирал бүр гаргаж Хороонд ирүүлнэ.

Долоо. Хариуцлага

7.1.Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн тохиолдолд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--